ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр Дугаар А/03 Арвайхээр сум

Тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр албан хаагчдад шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга: Ж.Ганзориг (Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Нарийн бичгийн дарга: Л.Доржханд (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Гишүүд: М.Эрдэнэчимэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Т.Үүрцайх (Иргэний төлөөлөл)
Б.Золбоо (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн)

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг цахим хэлбэрээр холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн барихыг үнэлгээний хорооны дарга (Ж.Ганзориг)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Л.Доржханд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:2024/Alban bichig/Zahiramj-2024

622411005